



МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

20 18 оны 11 дугаар
сарын 07 -ны өдөр

Дугаар 118

Улаанбаатар
хот

Журам батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.5-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Онцгой байдлын байгууллагын алба хаагчид онцгой гавьяа байгуулсан тохиолдолд мөнгөн урамшуулал олгох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Мөнгөн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг жил бүр улсын төсөвт тусгуулах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газар (хошууч генерал Т.Бадрал)-т даалгасугай.

Монгол Улсын Шадар сайд



Ө.ЭНХТҮВШИН



**ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИД ОНЦГОЙ
ГАВЬЯА БАЙГУУЛСАН ТОХИОЛДОЛД МӨНГӨН
УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Онцгой байдлын байгууллагын алба хаагчид онцгой гавьяа байгуулсан тохиолдолд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.5-д заасны дагуу мөнгөн урамшуулал олгоход энэ журмыг мөрдөнө.

1.2. Энэ журмын зорилго нь гамшиг, осол, аюулт үзэгдлийн бүс болон хүний гоц халдварт өвчний голомтод аврах, эмчлэх, сувилах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд эр зориг, мэргэжлийн ур чадвар гарган оролцож, онцгой гавьяа байгуулсан Онцгой байдлын байгууллагын алба хаагчийг тодруулах, түүнд мөнгөн урамшуулал олгох үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.3. Энэ журам нь онцгой гавьяа байгуулсан Онцгой байдлын байгууллагын алба хаагчид хамаарна.

**Хоёр. Онцгой гавьяа байгуулсанд
тооцох үндэслэл**

2.1. Дараах хүнд нөхцөлд үүрэг гүйцэтгэж хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг аварсан, аюулгүй болгосон алба хаагчийг онцгой гавьяа байгуулсанд тооцно.

2.1.1. Усны ослын үед 20 метр, түүнээс гүнд шумбаж, эрэн хайх, аврах, амь үрэгдэгсдийн цогцос, живсэн техник хэрэгслийг гаргах ажиллагааг бүрэн гүйцэтгэсэн;

2.1.2. Хүн ам, эд хөрөнгөд их хэмжээний хохирол учруулах хүчин чадал бүхий тэсрэх цэнэгийг таслан зогсоосон, аюулгүй болгосон;

2.1.3. Холер, тарваган тахал болон эдгээртэй адилтгах хэмжээний хохирол, хор уршиг учруулах эрсдэлтэй хүний гоц халдварт өвчний голомтод өвчлөгсдийг эмчлэх, сувилах үүрэг гүйцэтгэсэн;

2.1.4. Их хэмжээний хохирол, хор уршиг учруулах эрсдэлтэй мал, амьтны гоц халдварт өвчин, цацраг, хими, эрчим хүч, ослын голомтод мэргэжлийн өндөр ур чадвар гарган ажиллаж хүний амь нас, эрүүл мэндийг аварсан, тархалтыг зогсоосон;

2.1.5. Улсын онц чухал болон галын онц аюултай объект, инженерийн нарийн төвөгтэй байгууламж, тэсэрч, дэлбэрэх шатамхай бодис материалд эрчимтэй шаталт явагдаж хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн үед гал түймэр унтраах үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, олон хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө эрсдэхээс хамгаалсан;

2.1.6. Эрсдэлтэй нөхцөлд өндрийн аврах ажиллагааны үед хүний амь нас аварсан;

2.1.7. Амь хамгаалах тусгаарлах багтай ажиллаж агааргүй, хорт хий бүхий тэсрэх аюултай нөхцөлд уурхайн гүнээс хүний амь насыг аварсан;

2.1.8. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед шуурхай, найдвартай холбоогоор ханган олон хүний амь насыг авран хамгаалсан;

2.1.9. Хорлон сүйтгэх ажиллагаанаас олон хүний амь нас, эд хөрөнгийг авран хамгаалсан;

2.1.10. Газар хөдлөлтийн гамшгийн үед нурангид дарагдсан амьд нэрвэгдэгчийг илрүүлэх, аврах ажиллагааг гүйцэтгэсэн.

Гурав. Урамшуулалд нэр дэвшүүлэх

3.1. Тухайн аймаг, нийслэлийн Онцгой байдлын газрын дарга нь онцгой гавьяа байгуулсан алба хаагчид нэр дэвшүүлж, түүний тодорхойлолтыг Онцгой байдлын ерөнхий газрын даргад хүргүүлнэ.

3.2. Онцгой гавьяа байгуулсан алба хаагчийг тодруулах, түүнд олгох урамшууллын хэмжээг тогтоох, санал боловсруулах ажлын хэсэг (цаашид Ажлын хэсэг гэх)-ийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар томилно.

3.3. Ажлын хэсэг нь онцгой гавьяа байгуулж, урамшуулал авахаар нэр дэвшсэн алба хаагчийн тодорхойлолтыг нарийвчлан сайтар судалж, онцгой гавьяа байгуулсан эсэхийг тогтооно.

3.4. Ажлын хэсэг нь тухайн алба хаагчийг онцгой гавьяа байгуулсан байна гэж үзвэл энэ талаарх дүгнэлт, түүнд олгох урамшууллын хувь, хэмжээний тухай саналыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Урамшууллын хувь, хэмжээг тогтоох, олгох

4.1. Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн хурлаар ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцэн урамшууллын хувь, хэмжээг Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар тогтооно.

4.2. Онцгой байдлын ерөнхий газрын санхүүгийн асуудал эрхэлсэн нэгж нь алба хаагчид олгох урамшууллын мөнгийг санхүүжилт хийгдмэгц хууль тогтоомжийн дагуу тооцоог хийж, тухайн алба хаагчийн цалингийн дансанд шилжүүлнэ.

Тав. Санхүүжилт

5.1. Онцгой гавьяа байгуулсан онцгой байдлын байгууллагын алба хаагчдын мөнгөн урамшууллын зардлыг Онцгой байдлын ерөнхий газрын жил бүрийн төсөвт тусган олгоно.

Зургаа.Хариуцлага

6.1. Ажлын хэсэг нь судалгаа, шинжилгээ дүгнэлтийг буруу хийж, үндэслэл муутай санал гаргаж, хохирол учруулсан нь илэрвэл холбогдох албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль болон Цэргийн сахилгын дүрэмд заасан хариуцлага хүлээлгэнэ.

6.2. Урамшуулал авах алба хаагчид нэр дэвшүүлэх, тодруулах, түүнд олгох урамшууллын хувь, хэмжээг тогтооход албан тушаалын байдлыг урвуулан ашигласан байж болох зөрчил илэрвэл уг албан тушаалтныг шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт хүсэлт гаргана.

---oOo---